



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/378/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Акпар Аудит ХХК
Захирал: Х.Баянбай
Утас: 91919758 Цахим хаяг: akpar.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.УЯНГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хог, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/380
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,940,004.13	37,924,568.01
35	БАРАА МАТЕРИАЛ	14,940,004.13	37,924,568.01
351	Түүхий эд материал	8,672,334.50	33,924,663.60
35110	Тусгай зориулалттай материал	8,672,334.50	33,924,663.60
354	Хангамжийн материал	6,267,669.63	3,999,904.41
35410	Бичиг хэргийн материал	848,140.00	565,500.00
35420	Аж ахуйн материал	4,085,810.00	2,676,320.00
35440	Түлш, шатах тослох материал	1,333,719.63	758,084.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	936,015,921.74	1,056,062,968.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	936,015,921.74	1,056,062,968.08
392	Биет хөрөнгө	935,206,088.35	1,055,479,134.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	584,190,200.00	594,090,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,918,654.16)	(49,774,802.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,365,188.00	65,365,188.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,717,822.67)	(34,031,369.14)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,183,692,776.60	684,942,596.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(892,114,697.82)	(241,711,772.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,009,400.00	65,466,070.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,300,301.60)	(28,866,975.41)
393	Биет бус хөрөнгө	809,833.39	583,833.43
39301	Программ хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(320,166.61)	(546,166.57)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	950,955,925.87	1,093,987,536.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	950,955,925.87	1,093,987,536.09
51	Засгийн газрын хувь оролцоо	950,955,925.87	1,093,987,536.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	368,401,756.70	368,401,756.70
51101	Өмч: - төрийн	368,401,756.70	368,401,756.70
512	Хуримтлагдсан үр дүн	318,197,259.02	461,228,869.24
51210	Өмнөх үеийн үр дүн	324,317,101.33	318,197,259.02
51220	Тайлант үеийн үр дүн	(6,119,842.31)	143,031,610.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,356,910.15	264,356,910.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	950,955,925.87	1,093,987,536.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,954,319,287.13	2,263,795,699.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	474,076,947.13	529,762,169.93
120	Нийтлэг татварын бус орлого	474,076,947.13	529,762,169.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	474,076,947.13	529,762,169.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	277,059,511.00	267,982,016.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	197,017,436.13	261,780,153.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,480,242,340.00	1,734,033,529.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,398,010,600.00	1,467,390,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,398,010,600.00	1,467,390,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,231,740.00	266,643,029.79
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,827,140.00	193,863,929.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,404,600.00	72,779,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,960,365,212.70	2,120,426,416.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,960,365,212.70	2,120,426,416.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,842,253,911.84	1,930,282,514.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,120,016.10	1,100,155,506.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,195,178.50	157,204,954.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,139,200.00	61,794,300.00

Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	7,748,580.00	8,656,660.00
210402	Тээвэр, шатахуун	7,284,219.75	7,568,095.22
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,903,867.39	4,397,681.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,781,666.00	18,316,566.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,588,414.00	4,080,909.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	288,405,353.63	337,781,706.90
210502	Хоол, хүнс	4,787,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,554,500.00	26,705,590.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,540,000.00	2,244,300.00
210604	Урсгал засвар	5,371,647.00	20,930,088.00
210702	Дотоод албан томилолт	7,338,799.00	5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,725,000.00	37,832,334.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,452,200.00	7,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,189,000.00	1,451,959.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	243,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	75,457.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,249,595.15	4,340,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	840,750.00	1,454,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,614,336.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	226,190,632.32	122,687,814.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,111,300.86	190,143,901.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,165,600.00	115,624,250.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,585,300.00	95,200,024.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,380,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,200,000.00	20,424,226.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,945,700.86	74,519,651.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,945,700.86	74,519,651.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(6,045,925.57)	143,369,283.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73,916.74	337,673.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	73,916.74	337,673.43
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(73,916.74)	(337,673.43)
5	НИЙТ ҮР ДҮН	(6,119,842.31)	143,031,610.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон				/төгрөгөөр/
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	324,317,101.33	957,075,768.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	324,317,101.33	957,075,768.18
Тайлант үеийн үр дүн	-	-	(6,119,842.31)	(6,119,842.31)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	318,197,259.02	950,955,925.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	318,197,259.02	950,955,925.87
Тайлант үеийн үр дүн	-	-	143,031,610.22	143,031,610.22
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	461,228,869.24	1,093,987,536.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,757,301,851.00	2,002,015,545.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	277,059,511.00	267,982,016.00
120	Нийтлэг татварын бус орлого	277,059,511.00	267,982,016.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	277,059,511.00	267,982,016.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	277,059,511.00	267,982,016.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,480,242,340.00	1,734,033,529.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,398,010,600.00	1,467,390,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,398,010,600.00	1,467,390,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,231,740.00	266,643,029.79
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,827,140.00	193,863,929.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,404,600.00	72,779,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,715,831,651.00	1,984,358,645.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,597,720,350.14	1,793,738,900.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,120,016.10	1,099,473,206.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,195,178.50	157,411,411.22
210301	Гэрэл, цахилгаан	12,150,300.00	14,400,000.00
210302	Түлш, халаалт	14,619,200.00	14,619,400.00
210303	Цэвэр, бохир ус	17,873,700.00	23,846,900.00
210304	Байрны түрээс	5,496,000.00	8,928,000.00
210401	Бичиг хэрэг	7,450,140.00	7,520,110.00
210402	Тээвэр, шатахуун	7,718,200.00	5,718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,450,667.39	3,317,681.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,161,099.00	18,918,834.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,590,700.00	3,915,089.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,843,044.00	327,358,776.00
210502	Хоол, хүнс	4,787,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,941,300.00	26,963,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,940,000.00	2,244,300.00
210604	Урсгал засвар	8,228,750.00	21,020,000.00
210702	Дотоод албан томилолт	7,338,799.00	5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,725,000.00	32,332,334.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,452,200.00	12,836,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,189,000.00	1,451,959.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	243,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,457.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,185,795.15	4,620,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,530,304.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,111,300.86	190,619,745.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,165,600.00	116,100,094.03
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,585,300.00	95,200,024.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,380,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,200,000.00	20,900,070.03
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,945,700.86	74,519,651.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,945,700.86	74,519,651.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	41,470,200.00	17,656,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	41,470,200.00	17,656,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,470,200.00	17,656,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,470,200.00	17,656,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,470,200.00	17,656,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(41,470,200.00)	(17,656,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/		
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,718,954,300.00	1,665,878,536.63	53,075,763.37	96.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,718,954,300.00	1,665,878,536.63	53,075,763.37	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,698,054,200.00	1,644,978,466.60	53,075,733.40	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,057,943,700.00	1,014,244,396.45	43,699,303.55	95.9
210101	Үндсэн цалин	614,953,300.00	605,015,100.01	9,938,199.99	98.4
210102	Нэмэгдэл	224,817,600.00	204,411,694.61	20,405,905.39	90.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,552,000.00	120,551,912.36	87.64	100.0
210104	Урамшуулал	97,620,800.00	84,265,689.47	13,355,110.53	86.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,401,900.00	144,050,907.11	9,350,992.89	93.9
210201	Тэтгэврийн даатгал	103,244,700.00	103,709,659.74	(464,959.74)	100.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,839,400.00	2,694,100.99	5,145,299.01	34.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,043,000.00	16,400,535.37	2,642,464.63	86.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,115,900.00	1,816,753.42	299,146.58	85.9
210205	Эрүүл мэндийн даатгал	21,158,900.00	19,429,857.59	1,729,042.41	91.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,794,600.00	61,794,300.00	300.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	14,400,000.00	14,400,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	14,619,700.00	14,619,400.00	300.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	23,846,900.00	23,846,900.00	-	100.0
210304	Байрны түрээс	8,928,000.00	8,928,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,516,400.00	32,516,304.04	95.96	100.0
210401	Бичиг хэрэг	2,646,500.00	2,646,500.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,718,200.00	5,718,200.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,317,700.00	3,317,681.04	18.96	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,918,900.00	18,918,834.00	66.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,915,100.00	1,915,089.00	11.00	100.0
2105	Нормативт зардал	310,390,800.00	310,390,800.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	283,427,500.00	283,427,500.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	26,963,300.00	26,963,300.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,921,200.00	33,921,200.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,901,200.00	19,901,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	14,020,000.00	14,020,000.00	-	100.0
2107	Томилот, зочны зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилот	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,085,600.00	43,060,559.00	25,041.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,850,000.00	6,850,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,220,200.00	11,220,200.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,452,000.00	1,451,959.00	41.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,400.00	243,400.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,620,000.00	4,620,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17,100,000.00	17,075,000.00	25,000.00	99.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,900,100.00	20,900,070.03	29.97	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,900,100.00	20,900,070.03	29.97	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,900,100.00	20,900,070.03	29.97	100.0

Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,718,954,300.00	1,665,878,536.63	53,075,763.37	96.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,467,390,500.00	1,397,896,520.63	69,493,979.37	95.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,467,390,500.00	1,397,896,520.63	69,493,979.37	95.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	251,563,800.00	267,982,016.00	(16,418,216.00)	106.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	251,563,800.00	267,982,016.00	(16,418,216.00)	106.5
3	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
4	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛ				
61	Байгууллагын тоо	1	1		
62	Ажиллагсдын тоо	70	65		
62001	Удирдах ажилтан	1	1		
62002	Гүйцэтгэх ажилтан	52	54		
62003	Үйлчлэх ажилтан	17	10		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	266,643,029.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	266,643,029.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	266,643,029.79
210101	Үндсэн цалин	-	85,228,809.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	13,360,504.17
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,873,610.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	43,931,276.00
210604	Урсгал засвар	-	7,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	8,407,334.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,615,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	100,225,696.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	95,200,024.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		95,200,024.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг	-	5,025,672.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,025,672.00
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	266,643,029.79
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	266,643,029.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	193,863,929.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	72,779,100.00
3	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материал хуваарилах, анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно. Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 10-ны хооронд Акпар-Аудит компанийн захирал Х.Баянбай, аудитор С.Нарангэрэл нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Э.Нармандах хэрэгжүүлсэн.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эмгэг судлалын үндэсний төв нь эд эс, бүтэц судлал, онош зүй, лабораторийн шинжилгээний аргуудад тулгуурлан эмгэг судлалын онош тавьж, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлзүйн эмч нарын оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх, эмгэг судлалын тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус төв нь дотоод аудит, дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2021 онд хяналт шалгалт, дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 950,955.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 19,019.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,215.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гол зөрчил орлоготой холбоотой тул тайлант оны нийт орлогыг сонгож, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлан оны нийт орлого 2,263,795.7 мянган төгрөгөөс 2 хувь буюу 45,275.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эмгэг судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143,031.7 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	14,940.0	37,924.6	22,984.6
Үндсэн хөрөнгө	936,015.9	1,056,063.0	120,047.1
Нийт хөрөнгө	950,955.9	1,093,987.6	143,031.7
Засгийн газрын хувь оролцоо	368,401.8	368,401.8	-
Хуримтлагдсан үр дүн	318,197.2	461,228.9	143,031.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,356.9	264,356.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	950,955.9	1,093,987.6	143,031.7

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 120,047.1 мянган төгрөгөөр өссөн байна. “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5”-ийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/452 дугаар тушаал, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/799 дугаар тушаалаар хуваарилсан 189,648.1 мянган төгрөгийн хөрөнгө, худалдаж авсан 17,656.9 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 463 дугаар тогтоолоор актлагдсан хөрөнгө болон тайлант оны хуримтлагдсан элэгдлийн хэмжээгээр буурчээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 22,984.6 мянган төгрөгөөр өссөн байна. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор хандив болон нэмэлт санхүүжилтээр эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц бүрдүүлснээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Татварын бус орлого	474,077.0	529,762.2	55,685.2
Тусламж санхүүжилтийн орлого	1,480,242.3	1,734,033.5	253,791.2
Үйл ажиллагааны орлого	1,954,319.3	2,263,795.7	309,476.4
Цалин, шимтгэлийн зардал	1,134,315.2	1,257,360.5	123,045.3
Бусад бараа үйлчилгээний зардал	437,443.3	497,475.9	60,032.5
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,690.4	52,758.3	18,067.9
Бараа үйлчилгээний бусад зардал	235,805.0	122,687.8	(113,117.2)
Урсгал шилжүүлэг	118,111.3	190,143.9	72,032.6
Үйл ажиллагааны зардал	1,960,365.2	2,120,764.1	160,398.9
Үйл ажиллагааны үр дүн	(6,045.9)	143,369.3	149,415.2

2021 онд Эмгэг судлалын үндэсний төвийн төсөв татварын бус орлого 55,685.2 мянган төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 253,791.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Төсвийн болон нэмэлт санхүүжилтийн өсөлтийг дагаж үйл ажиллагааны зардал нь 160,398.9 мянган төгрөгөөр өсөж, тайлант оны эцэст 149,415.2 мянган төгрөгийн эерэг үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны урсгал зардалд 1,838,666.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийг 202,775.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,635,890.5 мянган төгрөгөөр баталжээ. Улсын төсвөөс 1,467,390.5 мянган төгрөг, өөрийн орлогоос 168,500.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан.

Батлагдсан төсвийг нэмэгдүүлэн тодотгож өгөх хүсэлтийг Эрүүл мэндийн ямаар дамжуулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч зөвхөн өөрийн орлогоор санхүүжүүлэх зөвшөөрөл олгож, батлагдсан төсвийг 83,063.8 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Төсвийн тодотголоор урсгал зардлыг 1,718,954.3 мянган төгрөгөөр, үүний 1,467,390.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 251,563.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,467,390.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 267,982.0 мянган төгрөгийн орлого оруулсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 16,418.2 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Улсын төсвөөс авсан санхүүжилтээс хэмнэгдсэн 69,494.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын төсвийн гүйцэтгэл 1,665,878.5 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь боловсон хүчний дутагдлаас болж орон тоо дутуу ажиллаж, цалин хөлс, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 193,863.9 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 72,779.1 мянган, нийт 266,643.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс резидент эмч нарын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрт 98,589.3 мянган, эм, эмнэлгийн хэрэгсэл, хангамжийн материал, урсгал засварт 67,828.0 мянган, нэг удаагийн тэтгэмжид 95,200.0 мянган, нийт 261,617.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,025.7 мянган төгрөгийг улсын төсөв төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дараах онцлох болон бусад асуудал байна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангийн 2021 оны 04 дүгээр улирлын сонгон шалгаруулалтад тус төвийн бичсэн “Эрүүл мэндийн байгууллагын үйлчлүүлэгч-төвтэй байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн судалгаа”-ны төсөл шалгарч, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Нийт санхүүжилт нь 7,480.0 мянган төгрөг бөгөөд гэрээнд заасны дагуу 70.0 хувийг буюу 5,236.0 мянган төгрөгийг урьдчилан авч, судалгааны ажлын хийж эхэлсэн байна. Төслийг хэрэгжүүлсний үр дүнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үйлчлүүлэгч-төвтэй байдлыг үнэлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, төлөвшүүлэх санал зөвлөмж боловсруулах;
- 2021 онд нийт орон тоог 70 хүнээр баталсан боловч боловсон хүчний дутагдлаас 65 хүн ажилласан байна. Орон тоо дутуу ажилласнаас төсөвт зардлыг 69,494.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 27 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 173 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шүүхийн шийдвэрээр битүүмжлэгдсэн автомашиныг орлого авсан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49.1 дүгээр заалт буюу “Хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах гэж тухайн хөрөнгийг захиран зарцуулах, түүнчлэн эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах ажиллагааг ойлгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилжих хөдөлгөөн хийх боломжгүй болсон дээрх автомашиныг битүүмжлэгдсэн газар болох Эрүүл мэндийн яаманд буцааж өгөх арга хэмжээ авах.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 38,665.7 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг жилийн эцсийн эцсийн аудитаар дахин хянахад шинжилгээний орлогод сугалааны баримт олгох зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 15,645.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. Үлдсэн 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй учир жилийн эцсийн тайлангаар дахин авч үзлээ.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт-3

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	12,954.2	4	12,954.2	-	-	100.0

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар битүүмжлэгдсэн Эрүүл мэндийн яамнаас үнэгүй шилжиж ирсэн 20,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, Ниссан Патрол маркийн суудлын автомашины асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,320.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн сайдын шийдвэрээр тус төвд ашиглагдахгүй 7 төрлийн 3,970.0 мянган төгрөгийн үнэтэй, хүчилтөрөгчийн маск, хүчилтөрөгчийн гуурс зэрэг эмнэлгийн хэрэгслүүдийг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн ямаар шийдвэр гаргуулан шаардлагатай газарт нь хуваарилуулах арга хэмжээ авах.

2. Үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шинжилгээний орлого 30,350.0 мянган төгрөгийн орлогод сугалааны дугаартай баримт олгоогүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Татварын хуульд заасны дагуу өөрийн үйл ажиллагаанаас орлого орох бүрд үйлчлүүлэгч нарт сугалааны дугаартай баримт олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/			
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс	
					Тоо	Дүн	Тоо	дүн
1	Эмгэг судлалын үндэсний төв	АХГ-2022/378/НА-СТА-ТШЗ	Шинжилгээний орлогод сугалааны дугаартай баримт олгоогүй байна.	зөвлөмж	1	30,350.0	1	30,350.0
2	Эмгэг судлалын үндэсний төв	АХГ-2022/378/НА-СТА-ТШЗ	Хэрэгцээгүй бараа үнэгүй шилжиж ирсэн	зөвлөмж	1	3,970.0	1	3,970.0
Дүн					2	34,320.0	2	34,320.0

